

Төмөр замын талаар авах зарим
арга хэмжээний тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн гишүүд “Төмөр замын талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын гишүүн, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Ц.Дашдоржийн танилцуулга, холбогдох баримт материалтай танилцаад ЗӨВЛӨМЖ болгох нь:

Нэг. Монгол Улсын Их Хуралд:

1. Төмөр замын суурь бүтэц эзэмшигч, тээвэрлэгчтэй холбоотой эрх зүйн зохицуулалтыг тодорхой болгох зорилгоор Төмөр замын тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар даруй хэлэлцэж, батлах арга хэмжээг авах.

Хоёр. Монгол Улсын Засгийн газарт:

1. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2011 оны 35/32 дугаар зөвлөмжийн Нэгийн 3 дахь заалтын хэрэгжилтийг хангах хүрээнд Сайншанд-Тавантолгой-Ухаахудаг-Гашуунсухайт, Сайншанд-Хөөт-Чойбалсан, Хөөт-Нөмрөг чиглэлийн төмөр замыг нэгдсэн сүлжээ болгох зорилгоор суурь бүтцийн барилга угсралтын ажлын концессыг шууд гэрээний үндсэн дээр олгож, 2012 оны эхний хагас жилд багтаан зэрэг эхлүүлэх.